



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/444

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.6-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж буй ажилтнуудын орон сууцны нөхцлийг сайжруулах зорилгоор хөнгөлөлттэй нөхцлөөр баригдах орон сууцанд хамруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.


2. Төрийн албан хаагчдын орон сууцны судалгааг гарган, зохион байгуулалт хийх, шийдвэрлэх үйл явцыг тооцоо судалгаагаар гүйцэтгэх, хяналт тавих, тайлагнан ажиллахыг Ажлын хэсэг /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.

**ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



Д.РЭНЦЭНБЯМБА

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2020 оны 03 дугаар сарын
03 -ний өдрийн А.Мунтушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Төмөрбаатар

Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

А.Мөнгөн

Захиргаа санхүүгийн хэлтсийн даргын үүрэг
гүйцэтгэгч

Н.Уранчимэг

Ерөнхий нягтлан бодогч

Н.Золжаргал

Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах, хүний
нөөцийн мэргэжилтэн

Ч.Мөнхбаяр

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн ахлах
мэргэжилтэн

С.Ариунжаргал

Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн
мэргэжилтэн

Зөвлөлийн нарийн бичиг:

М.Мандах

Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн
дарга